

Нуугдсан файлыг хялбар аргаар хэрхэн харж болох вэ?

Таньд хааяа нуугдсан фолдер юмуу файлаа хайж олох амаргүй үе тулгардаг уу? Тэгвэл таньд 3 төрлийн үйлдлийн систем дээр нуугдсан файл олох аргыг хүргэж байна. Дараах зааврын дагуу хийгээрэй.

1. Хэрэв та Windows XP хэрэглэдэг бол:

1. Зүүн доод булан дахь **Start** товчийг дарна
2. **Control Panel** цэсийг дарснаар тус цонх нээгдэнэ.
3. Дараах 2 аргын аль нэгийг сонгон **Folder options** цонхыг нээснээр та нуугдсан файлаа харах болно.



Нэгдүгээр арга. Хэрэв **Control Panel** цонх уламжлалт загвараараа дээрээ цэстэйгээр нээгдвэл, Дараах алхмуудыг хийгээрэй.

1. **Tool** хэсгээс **Folder Options** цэсийг сонгоно.
2. **View** табыг дарна.
3. **Show hidden files and folders** сонголтыг дарж идэвхжүүлнэ.
3. **OK** дарж гарснаар нуугдсан фолдер, файлууд харагдана.




Хоёрдугаар арга. Хэрэв **Control Panel** цонх категор буюу багцалсан хэлбэрээр дээрээ цэсгүй байвал дараах алхамыг хийгээрэй.

1. Цонхны **Appearance and Themes** гэх линкийг дарж нээнэ.
2. **Appearance and Themes** линк нээгдсэний дараа **Folder Options** линкийг дарна.
3. **View** табыг дарна.
4. **Show hidden files and folders** сонголтыг сонгож дарна.
5. **OK** дарж гарснаар нуугдсан фолдер, файлууд харагдана.




2. Хэрэв та Windows Vista хэрэглэдэг бол:

1. Зүүн доод булан дахь **Start** товчийг дарна
2. **Control Panel** цэсийг дарснаар тус цонх нээгдэнэ.
3. **Control Panel** цонхны зүүн хэсэгт байх **Classic View** товчийг дарж нээнэ.
4. **Folder Options** товчийг дарж нээнэ.
5. **View** табыг дарна.
6. **Show hidden files and folders** сонголтыг дараарай.
7. **OK** дарж гарснаар нуугдсан фолдер, файлууд харагдана.



3. Хэрэв та Windows 7 хэрэглэдэг бол:

1. Зүүн доод булан дахь **Start** товчийг дарна
2. **Control Panel** цэсийг дарж тус цонхыг нээнэ.
3. Баруун дээд хэсэгт байгаа харагдах хэлбэрийг сонгох цэс буюу **View by: Category** цэснээс **Small icons** –ийг сонгож нээнэ.
4. Нээгдсэн олон цэснээс **Folder Options** цэсийг сонгоно.
5. **View** табыг дарна.
6. **Show hidden files and folders** сонголтыг дараарай.
7. **OK** дарж гарснаар нуугдсан фолдер, файлууд харагдана.



Хэрэв дээрх аргыг хэрэглээд ч таны нуугдсан фолдер юмуу файл чинь харагдахгүй бол доорх аргийг хэрэглээрэй.

1-р алхам

Дараах файлыг татаж өөрийн компьютертээ хуулж авна. Дараах файл татах товчийг дараад та юу ч хийхгүй хүлээгээрэй. Хаана хадгалахыг асуувал дэлгэцэн дээрээ хадгалаарай.



Файл татах: [AutorunExterminator](#).

Компьютертаа хадгалсан AutorunExterminator программаа асаагаарай. Энэхүү жижигхэн программ нь файл нуугаад байгаа вирусыг илрүүлнэ.

Одоо нуугдсан файльтай флаш дискээ компьютертаа холбоно. Үүний дараа хадгалсан программ маань өөрөө автоматаар autorun.inf файлыг илрүүлж флаш диск болон бусад дискүүдээс устгана.


2-р алхам

Зүүн доод булан дахь **Start** товчийг дарна. Хайх нүдэнд **cmd** гэж бичээд ENTER дарж нээнэ. Эсвэл **cmd** гэж бичихэд хайлтаар **cmd** гэж илэрсэнийг дарж нээнэ. (**cmd** нь тушаалын мөр буюу цонх юм)



Дараа нь гарч ирсэн хар цонх буюу тушаалын мөрөнд доорх командыг бичнэ.

attrib -h -r -s /s /d g:*.*




Коммандыг бичихдээ **g:** үсэг дээр анхаарах хэрэгтэй. Энэ нь флашыг тэмдэглэсэн үсэг юм.

Миний хувьд флаш диск маань компьютерт **g:** үсгээр танигдсан байгаа учраас **g:** гэж бичсэн.

Та флаш дискийнхээ танигдсан үсгийг орлуулж бичих хэрэгтэй. Өөрийнхөө флаш дискнийхээ үсгийг мэдэхдээ **My computers** -руу ороход **Removable disk (G:)** гэсэн хэсэгт хашилтан дотор байгаа.


g: үсгийг мэдэх өөр нэг арга нь флашаа холбоход баруун доод хэсэгт гардаг флашны зураг дээр дарж мэдэж болно.



Одоо үсгээ мэдсэн бол хар цонх буюу тушаалын мөрөндөө дараах командыг бичээрэй. Бичихдээ флашныхаа үсгийг орлуулж бичихээ бүү мартаарай.

attrib -h -r -s /s /d g:*.*

Бичихэд төвөгтэй байвал та дээрх командыг **Copy**-дож аваад тушаалын мөрөндөө курсораа тавьж байгаад хулганыхаа баруун товчийг дарж **Paste** -ийг сонгож хуулж тавьж болно. Курсораа гүйлгэж **g:** үсгийг устгаад өөрийнхөөрөө сольж бичээрэй.



Дахин хэлэхэд та флаш дискнийхээ үсгийг өөрийнхөөрөө солихоо мартуузай.

Одоо **Enter** дарна.

Одоо флаш дискрүүгээ орж файлаа шалгаж үзээрэй.

Амжилт хүсье.